

WEGO Итгэлийн Тунхаг

Энэ бол энгийн нэг итгэлийн тунхаг эсвэл итгэлийн систем төдий зүйл биш юм – энэ бол WEGO-ийн бусадтай хуваалцахын тулд оршин буй утга учир билээ. Энэ бол дэлхий даяарх манай ажилчид, удирдах зөвлөл, сайн дурын үйлчлэгч нарын зүрх сэтгэлийг дүүргэсэн Есүсийн Сайн Мэдээ юм. Үнэний бодит байдал бидний зүрх сэтгэлийг Бурханд алдар магтаал өргөхөд уриалж мөн амьдралыг маань үйлдэл уруу хөтлөх болтугай.

Библи

Библи нь үнэн, төгс, алдаагүй Бурханы үг бөгөөд Бурхан Өөрийгөө хүн төрөлхтөнд илчлэн харуулахаар өгсөн гэдэгт бид итгэдэг. Энэ нь Ариун Сүнсний сүнслэг онгодоор дамжуулан хүнээр бичигдсэн ба Христ итгэгчдийн итгэл болон амьдралын эрх мэдлийн үндэс билээ.

Дэд Хууль 17:9; Дуулал 19:7-10; Лук 24:44-46; Ром 15:4; 2 Тимот 3:15-17; 2 Петр 1:20-21

Бурхан

Цорын ганц үнэн Бурхан байдаг бөгөөд Тэрээр гурвалаар оршин байдагт бид итгэдэг: Эцэг, Хүү, Ариун Сүнс. Тэр бол библийн Зохиолч, Бүтээгч, орчлон ертөнцийн Захирагч бөгөөд бүх зүйл Түүний алдарын төлөө оршин байдаг.

Эхлэл 1:1; Гэтлэл 3:14; Дэд Хууль 6:4; Иеремиа 10:10; 1 Коринт 8:6; Ефес 4:6

Есүс Христ

Есүс Христ бол Бурханы цорын ганц Хүү бөгөөд энэ дэлхий дээр хүний махан биеийг өмсөн ирсэн гэдэгт бид итгэдэг. Тэр бол бүрэн дүүрэн Бурхан ба бүрэн дүүрэн хүн бөгөөд Эцэг болон Ариун Сүнсстэй эн тэнцүү оршин байдаг. Есүс Ариун Сүнсээр олдож, онгон төрөлтөөр төрж, гэм нүгэлгүй төгс амьдралаар амьдарсан. Түүний үйлдсэн гайхамшиг нь Түүний тэнгэрлэг мөн чанарын баталгаа болж, Түүний сургаал нь Түүний эрх мэдлийг илэрхийлж, Тэрээр бидний гэмийн төлөө загалмай дээр цовдлуулан нас барж, дахин амилалтаараа үхэл болон гэмийн хүчийг ялан дийлсэн юм. Тэрээр тэнгэрт өргөгдөн Бурхан Эцэгийнхээ баруун гарт заларч, нэгэн өдөр биет байдлаар дахин ирж захирах болно.

Исаиа 7:14; Марк 1:1; Иохан 1:1-18; Ром 1:3-4; Ефес 1:22-23; Колоссай 1:13-22; Еврей 1:1-3

Ариун Сүнс

Бурхан Сүнс нь Эцэг болон Хүүтэй эн тэнцүү оршин байдаг гэдэгт бид итгэдэг. Тэрээр хүмүүсийг Бурхан уруу удирдаж, тэднийг босгон байгуулах ажил үүргийг гүйцэтгэж, итгэгч нэг бүрийн дотор оршин байдаг. Ариун Сүнс нь хүч чадал, гэмшил, мэргэн ухаан өгч мөн ариун амьдрал уруу удирдан чиглүүлдэг. Тэр бол тайвшруулагч, бидний төлөө зуучлан залбирагч, сүнслэг бэлэг авъяасыг өгөгч, итгэгчдийн авралын баталгаа бөгөөд шүүлтийн өдрийг хүртэл бүх итгэгчид Ариун Сүнсээр тамгалагдсан байдаг.

Эхлэл 1:2; Исаиа 61:1-3; Матай 1:18; Лук 12:12; Ром 8:16; 1 Коринт 2:14; Галат 4:6; Ефес 1:13-14

Хүн Төрөлхтөн

Хүн төрөлхтөн анх Бурхантай харилцаатай байхаар Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн гэдэгт бид итгэдэг. Сатаны уруу татлагаас болж Адам Ева хоёр дуулгаваргүй байдлыг сонгосны улмаас дэлхийд гэм нүгэл орж ирсэн. Үүний дүр дүнд бүх хүн төрөлхтөн өөрийн Бүтээгчээс мөнхөд тусгаарлагдаж мөн Бурханы шийтгэл авбал зохих өстөн дайсан болж хаягдсан бөгөөд хүн төрөлхтөн өөрийгөө аврах боломжгүй болсон.

Эхлэл 1:26-30; Иеремиа 17:5; Ром 1:19-32; Ром 5:12; Ефес 2:1-22; Колоссай 1:21-22

Аврал

Аврал бол гэм нүгэлд унасан хүн төрөлхтөнд Есүс Христээр дамжуулан өгсөн ариун Бурханы үнэгүй бэлэг гэдэгт бид итгэдэг. Энэ нь хичээл зүтгэлээр биш Бурханы нигүүлсэл бөгөөд гэм нүглээсээ Бурхан уруу эргэн авралыг итгэлээр хүлээн авдаг бөгөөд аврал нь бидний төлөө Христийн бүрэн дүүрэн ажил үйлчлэлийг хувчилан хүлээн авч, Есүсийг Аврагч Эзэн хэмээн өчих юм. Есүсийн дотор бид амьтай болж Түүний зөвт байдлыг хүлээн авсан. Христээр дамжуулан бид Бурхантай эвлэрч улмаар шинэ бүтээл болсон. Гэм нүглийн хүлээс болон хуулийн хараалаас бид чөлөөлөгдсөн. Христээр дамжуулан Бурхан биднийг үрчлэн авч, Өөрийн хайрт хүүхэд болгон, Өөрийн хязгааргүй нигүүлсэлийн баялгыг бидэнд үзүүлсэн.

Матай 1:21; Ром 1:16–18; Ром 3:23–25; Ром 5:8–10; 2 Коринт 5:17–20; Галат 3:13

Нигүүлсэлээр дамжуулан зөвхөн итгэлээр

Есүс Христэд итгэх итгэлээс ангид аврал гэж байхгүй гэдэгт бид итгэдэг. Хүн төрөлхтөний хичээл зүтгэл, хуулийг захих байдал, зан үйл, ёслол, сайн үйл нь зөвт байдал болон уучлалыг олж авах гэсэн хүний өөрийн оролдлого бөгөөд үүгээрээ гэмд унахаас өмнөх дүр төрхөө хэзээ ч дахин сэргээж чадахгүй. Аврал бол Бурханы нигүүлсэлээр бүрэн дүүрэн болсон Бурханы ажил бөгөөд зөвхөн Есүсээр дамжин ирсэн бидэн дээр асгарсан Түүний хайрын золиослол юм. Жинхэнэ итгэгч хүний бат итгэл нь өөрийн үйлдэл дээр суурилсан биш харин зөвхөн Бурханы хүч чадал, Түүний авралын баталгаа, Өөрийн хүмүүсийг хамгаалан сахих амлалтан дээр суурилсан байдаг.

Иохан 14:6; Ром 6:14; 1 Коринт 1:27-31; Галат 2:16; Ефес 2:1-10; Колоссай 2:13-17

Чуулган

Христийн бие ба сүйт бүсгүй болсон чуулган нь Христийн авралын ажлаар дамжуулан Бурханы доор нэгдсэн бүх итгэгч нарын сүнслэг нөхөрлөл гэдэгт бид итгэдэг. Чуулганы бүх гишүүд нь дараах байдлаар дуудагдсан: нутгын чуулганы бие болон оролцох, нутгын чуулгандаа итгэлээр дасгалжуулагдах, баптисмийн ёслолд оролцох, халамж үйлчилгээ авах, хариуцлагатай байх, нөхөрлөл дотор амьдрах, ариун амьдрал дотор алхах, хамтдаа хүндэтгэл мөргөл өргөх, Бурханы хаанчлалын төлөө бэлтгэгдэх.

Дуулал 107:32; Үйлс 2:41–42; Үйлс 20:28; Ром 12:4-5; 1 Коринт 1:2; Колоссай 1:18; Еврей 10:19-25

Агуу Захирамж

Есүс чуулганыг дэлхийн хязгаар хүртэл явж, бүх үндэстэнийг дагалдагч болгож, баптисм хүртээж, итгэсэн хүмүүст заа гэж тушаасан гэдэгт бид итгэдэг. Христийн элчин сайдын хувьд Христийн хайр, Бурханы авралын сайн мэдээг дэлхийн бүх хүмүүст хуваалцана гэдэг бол бидний дуудлага мөн бидний хувьд аз завшаан билээ.

Матай 9:37–38; Матай 24:14; Матай 28:16-20; Үйлс 1:8; Ром 10:13–15; 2 Коринт 5:20

Дахин Амилалт

Бүх хүн төрөлхтөн мөнхөд оршин байхаар бүтээгдсэн гэдэгт бид итгэдэг. Христийн дотор үл оршигч нэгэн нь дахин амилж, мөнхийн шийтгэлийг авч Бурханаас тусгаарлагдан тамд хаягдах болно. Христийн дотор оршигч нэгэн нь дахин амилж, Бурхантай хамт диваажинд мөнхөд орших үл муудах шагналыг авах болно.

Матай 25:31-46; Иохан 5:24; Иохан 5:28-29; Үйлс 24:15; Ром 6:23; Галат 6:8